



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/99

Улаанбаатар хот

Г Баталгаажуулалтын шинжээчийн дүрэм Г  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 25.3.1, Засгийн газрын 291 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын 2.8, Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага - ISO IEC 17065 стандартын 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Баталгаажуулалтын шинжээчийн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү дүрмийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2006 оны 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БИЛГҮҮН



028012508



## Баталгаажуулалтын шинжээчийн дүрэм

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хууль, ISO IEC 17065 стандарт болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалтыг явуулах итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын баталгаажуулалтын шинжээчийн /цаашид “баталгаажуулалтын шинжээч” гэх/ ажлын хүрээ, тавигдах шаардлага, эрх үүрэг, хариуцлага, эрх олгох, аттестатчилах үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зэрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд баримтлах олон улсын стандарт, арга зүйн удирдамжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3 Холбогдох хууль тогтоомж, журам, стандартын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцад тохирлын үнэлгээг гүйцэтгэх эрх бүхий ажилтан нь “Баталгаажуулалтын шинжээч” байна

1.4 Баталгаажуулалтын шинжээч нь үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэгтэй байна.

1.5 Баталгаажуулалтын шинжээчийн эрхийг 4 хүртэл жилийн хугацаагаар олгоно.

1.6 Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагууд дагаж мөрдөнө.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1 Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцох орон тооны болон орон тооны бус баталгаажуулалтын шинжээчид хамаарна.

2.2 Менежментийн тогтолцооны аудиторт хамаarahгүй.

### Гурав. Норматив эшлэл.

3.1 MNS ISO 17000:2005 Тохирлын үнэлгээ – Тайлбар толь, өрөнхий зарчим

3.2 MNS ISO PAS 17001:2006 Тохирлын үнэлгээ-Шударга байдал, зарчим,

3.3 СХЗГ-ын даргын А/310 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын журам”.

#### **Дөрөв. Баталгаажуулалтын шинжээчийн баримтлах зарчим**

- Ес зүйг дээдлэнэ;
- Шударга ёсыг сахина;
- Ил тод, хараат бус байна;
- Мэргэжлийн өндөр ур чадвартай байна;

#### **Тав. Баталгаажуулалтын шинжээчийн ангилал, ажлын хүрээ**

5.1 Баталгаажуулалтын шинжээч нь орон тооны болон орон тооны бус байна.

5.1.1 Үндсэн эрхэлдэг албан тушаал, ажил үүргийнхээ хүрээнд баталгаажуулалт явуулдаг ажилтныг орон тооны баталгаажуулалтын шинжээч гэнэ.

5.1.2 Байнгын үндсэн үүрэгт ажилд нь хамаардаггүй боловч баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр нарийн мэргэжлийн тохирлын үнэлгээ явуулах ур чадвар бүхий ажилтныг орон тооны бус баталгаажуулалтын шинжээч гэнэ.

5.2 Баталгаажуулалтын шинжээчийн үйл ажиллагааны хүрээгээр нь:

- тодорхой нэрийн бүтээгдэхүүн, салбарын (хүнс, зам, барилгын материал, үйлчилгээний ....)

#### **Зургаа. Баталгаажуулалтын шинжээчийн мэргэжил, мэргэшлийн шалгуур, тавигдах шаардлага**

6.1 Баталгаажуулалтын орон тооны шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1 Техникийн болон байгалийн шинжлэх ухааны чиглэлээр Бакалавараас доошгүй боловсролын зэрэгтэй, албан ажлын хүрээнд дэлхий нийтийн болон олон улсын байгууллагад ажлын хэл гэж тооцогддог 1-ээс доошгүй гадаад хэл (орос, англи, хятад.. гэх мэт)-ний дундаас дээш түвшний мэдлэгтэй байна.

6.1.2 Стандартчилал, тохирлын үнэлгээний болон мэргэжлийн чиглэлээр жилдээ 16 цагийн хөтөлбөрт сургалтад хамрагдсан байна.

6.3 Баталгаажуулалтын орон тооны бус шинжээч нь энэ журмын 6.1.1, 6.1.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна тухайн эрх авсан мэргэжлийн

чиглэлээр 10 жилээс доошгүй хугацаагаар ажилласан, тохирлын үнэлгээний чиглэлийн мэдлэгтэй, дадлага туршлагатай байна.

6.4 Бодит баримт, нотолгоон дээр тулгуурлан дүгнэлт гаргах чадвартай байна.

*Тайлбар: Энэ дүрмийн 6.1.2-т заасан сургалтад хамрагдсан байх гэдэгт семинар, хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцсоныг тооцож болно.*

### **Долоо. Баталгаажуулалтын шинжээчийн эрх, үүрэг, хариуцлага**

- 7.1 Олгосон эрхийн хүрээнд тохирлын үнэлгээг явуулах;
- 7.2 Тохирлын үнэлгээний ажлыг баталгаажуулалтын схем, журмын дагуу холбогдох хууль, тогтоомж, журмын хүрээнд гүйцэтгэх;
- 7.3 Үнэлгээний ажлын үнэн зөв, бодит, шударга байдлыг биечлэн хариуцах;
- 7.4 Тохирлын үнэлгээний ажлын хүрээнд холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, мэдээ баримтыг авч танилцах, бүтээгдэхүүнээс дээж авах, түүнийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэх;
- 7.5 Баталгаажуулалтад тэнцээгүй, техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангагүй бүтээгдэхүүний талаар холбогдох мэргэжлийн болон бусад байгууллагад мэдэгдэх;
- 7.6 Баталгаажуулалтын шинжээчийн болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих,
- 7.7 Үнэлгээний үйл ажиллагааг гүйцэтгэх явцад олж авсан буюу бий болсон холбогдох хуульд зааснаас бусад бүх мэдээллийн нууцыг хадгалах,
- 7.8 Баталгаажуулалтын шинжээч нь өөр баталгаажуулалтын байгууллагад давхар ажил эрхлэхгүй байх,
- 7.9 Өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшинг байнга дээшлүүлэх, ажил үүргээ өндөр түвшинд гүйцэтгэх,
- 7.10 Баталгаажуулалтын шинжээчийн үнэмлэх, тэмдгийг дур мэдэн бусдад шилжүүлэх, ашиглуулах, барьцаалах, хадгалуулах, үрэгдүүлэх, хууль бусаар хийлгэх, хэлбэр загварыг өөрчлөх, хувилах, албаны бус ажилд ашиглахгүй байх,
- 7.11 Гарын үсэг зурж баталгаажуулсан тохирлын гэрчилгээ, тохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт, бусад баримт бичгийг засварлах, өөрчлөхгүй байх,
- 7.12 Баталгаажуулалтын шинжээчийн тэмдгийг дараах албан ёсны баримт бичгийг баталгаажуулах зорилгоор хэрэглэнэ. Үүнд:
  - 7.13.1 Тохирлын гэрчилгээ;
  - 7.13.2 Аюулгүйн тэмдгийн гэрчилгээ;

7.13.3 Шинжээчийн дүгнэлт;

7.13.4 Дээж авсан тэмдэглэл.

7.13 Баталгаажуулалтын шинжээч нь тохирлын үнэлгээнд тэнцээгүй тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг /хавсралт-1/ үйлдэж, хүсэлт гаргагч байгууллагад хүргүүлэх;

7.14 Баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцөөр хангагдсан байх,

7.15 Тохирлын үнэлгээний дүнд сөргөөр нөлөөлөхгүй, баталгаажуулалтын талаар аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд шаардагдах тайлбар, тодруулга, мэдээллийг өгөх,

7.16 Тохирлын үнэлгээний үр дүнг баталгаажуулалтын зөвлөл болон удирдлагад тайлагнах, холбогдох шийдвэрийг гаргуулах,

7.17 Баталгаажуулалтын орон тооны бус шинжээч нь баталгаажуулалтын байгууллагатай гэрээ байгуулах, байгуулсан гэрээг цуцлах талаар санал гаргах,  
Тайлбар:

- Баталгаажуулалтын шинжээчийн тэмдгийг зөвхөн орон тооны баталгаажуулалтын шинжээч ашиглана.
- Энэхүү журмын 7.5, 7.12 заалт орон тооны бус шинжээчид хамаарахгүй.

#### **Найм. Баталгаажуулалтын шинжээчид эрх олгох**

8.1 Баталгаажуулалтын шинжээчийн эрх авах хүсэлтэй, энэ дүрмийн 6-р бүлгийн 6.1.1-ийн шаардлагыг хангасан ажилтан нь дараах материалыг СХЗГ-т ирүүлнэ. Үүнд:

- a/ Өргөдөл
- b/ Анкет /хавсралт -2/
- в/ 2 хувь цээж зураг /3\*4/
- г/ Мэргэжлийн диплом, хуулбарын хамт,
- д/ Гадаад хэлний мэдлэг эзэмшсэн гэрчилгээ, хуулбарын хамт.
- е/ Баталгаажуулалтын байгууллагын албан хүсэлт, ажил байдлын тодорхойлолт.

8.2 Энэ журмын 6.1.1-д заасан шаардлагыг хангасан хүмүүсийг ажлын 10 хоногийн 96 цагийн (үүнээс нийт сургалтын хугацааны онолын хичээлд 60%, дадлагын ажилд 40 % байхаар хөтөлбөрийг боловсруулна.) сургалтад хамруулна.

8.3 Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох шалгалтыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар томилогдсон шалгалтын комисс зохион байгуулж,

шалгалтын дүнг үндэслэн тус байгууллагын даргын тушаалаар шинжээчийн эрх олгоно.

8.4 Баталгаажуулалтын шинжээчийн эрхийг;

8.4.1 Анх удаа шинээр эрх олгоход 2 жилийн хугацаагаар;

8.4.2 Эрх сунгахад 4 жилийн хугацаагаар тус тус олгоно.

8.5 Шалгалт зохион байгуулах ажлын хэсэг нь эрх олгох шалгалтыг 60-аас доошгүй асуулт бүхий тестийн болон ярилцлагын хэлбэрээр явуулж, шалгалтын дүнг гаргана.

8.6 Онолын шалгалтыг цахим хэлбэрээр авах ба шалгалтын үргэлжлэх хугацаа 1 цаг 15 минут байна

8.7 Шалгалтад хамрагдсан ажилтнуудын шалгалтын дүнг А /100-90%/ буюу шаардлагаас дээгүүр, В /75-89.%/ буюу шаардлагын хэмжээнд, С /75%-аас доош/ буюу шаардлага хангахгүй гэсэн үнэлгээгээр үнэлнэ.

8.8 Шалгалтын дүнгээр С /75%-иас доош/ буюу шаардлага хангахгүй үнэлгээ авсан ажилтанд баталгаажуулалтын шинжээчийн эрх олгохгүй.

8.9 Баталгаажуулалтын шинжээчийн эрх авсан ажилтны нэгдсэн бүртгэлийг СМЛСҮТөв хөтөлж, тухай бүр нийтэд мэдээлнэ.

8.10 Баталгаажуулалтын эрх олгох шалгалтад хангалтгүй дүн авсан ажилтныг СХЗГ-ын төлөвлөгөөт сургалтад 1 удаа хамруулж, эрх олгох ажлыг энэ журмын 8.3-ийн дагуу хэрэгжүүлнэ.

#### Ҷ. Баталгаажуулалтын шинжээчийн эрх сунгах /аттестатчилал/

9.1 Баталгаажуулалтын шинжээчийн ур чадвар, мэргэшлийн түвшинд шинжээчийн эрхийн хүчинтэй хугацаанд мэргэжлийн шалгалт буюу аттестатчилал цаашид аттестатчилал гэнэ/ явуулна.

9.2 Баталгаажуулалтын шинжээч нь шинжээчийн эрхийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө эрх сунгуулах хүсэлтээ СХЗГ-т ирүүлнэ.

9.3 Аттестатчиллыг СХЗГ-ын даргын тушаалаар томилогдсон шалгалтын комисс зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.

9.4 Аттестатчилалд хамрагдах баталгаажуулалтын шинжээчид нь ажил байдлын тодорхойлолт, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайланг аттестатчилал эхлэхээс нэг сарын өмнө СХЗГ-т ирүүлнэ.

9.5 Аттестатчиллын комисс нь 60-аас доошгүй асуулт бүхий тестээр шалгалт авч, баталгаажуулалтын шинжээчийн эрхийг сунгах, эс сунгах шийдвэрийг СХЗГ-ын даргын тушаалаар гаргана.

9.6 Аттестатчиллын хамрагдсан ажилтнуудын шалгалтын дүнг А /100-90%/ буюу шаардлагаас дээгүүр, В /75-89.%/ буюу шаардлагын хэмжээнд, С /75%-аас доош/ буюу шаардлага хангахгүй гэсэн үнэлгээгээр үнэлнэ.

9.7 Аттестатчиллын дүнгээр С /75%-иас доош/ буюу шаардлага хангахгүй үнэлгээ авсан шинжээчийг нэг сарын дотор давтан аттестатчилалд хамруулах бөгөөд давтан аттестатчиллаар шаардлага хангахгүй үнэлгээ авсан тохиолдолд баталгаажуулалтын шинжээчийн эрхийг цуцлах буюу сунгах асуудлыг түдгэлзүүлнэ.

9.8 Аттестатчилалд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцож чадаагүй баталгаажуулалтын шинжээч нь хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримтыг өргөдлийн хамт СХЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ.

9.10 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аттестатчилалд хамрагдаагүй баталгаажуулалтын шинжээчийн эрхийг хүчингүй болсонд тооцно.

#### **Арав. Бусад**

10.1 Баталгаажуулалтын шинжээч нь албан үүргээ хангалтгүй биелүүлсэн болон албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн, шинжээчийн буюу төрийн албан хаагчийн ёс зүйн болон бусад зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2 Баталгаажуулалтын шинжээчдийн эрх олгох шалгалт, аттестатчилал явуулах болон энэ дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг СХЗГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

10.3 Баталгаажуулалтын шинжээч нь өөр ажилд шилжсэн, ажлаас гарсан тохиолдолд шинжээчийн тэмдгийг хураан авах, шинжээчийн эрхийг хүчингүй болсонд тооцож, бүртгэлээс хасна.

..... о О о .....

Стандарт, хэмжил зүйн газрын даргын  
2019 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн  
1/99 дугаар тушаалын 1-р хавсралт

**БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ**

БАЙГУУЛЛАГЫН НЭР: " " ХХК

БАЙРШИЛ:

ТАЙЛАНГИЙН ДУГААР:

СТАНДАРТ, НОРМАТИВ БАРИМТ БИЧИГ:

ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

ДҮГНЭЛТ:

Дүгнэлт гаргасан :

нэр

гарын үсэг

Албан тушаал

Стандарт, хэмжил зүйн газрын даргын  
2019 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн  
A/99 дугаар тушаалын 2-р хавсралт



**БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШИНЖЭЭЧИЙН  
ЭРХ АВАХЫГ/АТТЕСТАТЧИЛАД ХАМРАГДАХЫГ ХҮСЭГЧИЙН  
АНКЕТ**

- |                          |            |           |     |
|--------------------------|------------|-----------|-----|
| 1. Овог:                 | 2. Нэр:    |           |     |
| 3. Төрсөн он, сар, өдөр: | 4. РД:     |           |     |
| 5. Баталгаажуулалтын     | мэргэжлийн | чиглэл    |     |
| 6. Дээрхи                | мэргэжлээр | ажилласан | жил |

№	Хаана ямар байгууллагад	Хэдээс хэдэн онд

Баталгаажуулалтын үйл ажиллагаанд сүүлийн 2 жил оролцсон талаарх мэдээлэл

(Энэхүү шаардлага нь анх удаа эрх авах хумүүст хамаарахгүй)

[View Details](#) | [Edit](#) | [Delete](#)

7. Мэргэжил болон эрдмийн зэрэг цол (бакалавр, магистр, доктор)

---

---

- ## 8. Эзэмшсэн гадаад хэлний мэдлэг:

9. Баталгаажуулалтын мэргэжлийн мэдлэгийг илэрхийлэх үзүүлэлт (мэргэшүүлэх сургалт):

---

---

---

Огноо: 20 . . . оны . . . сарын . . . өдөр

Гарын үсэг: \_\_\_\_\_ / . . . . . . . /

Стандарт, хэмжил зүйн газрын даргын  
2019 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн  
19 дугаар тушаалын 3-р хавсралт

**БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ/АТТЕСТАТЧИЛАХ**  
**ШАЛГАЛТЫН ХУУДАС № \_\_\_\_\_**

Баталгаажуулалтын шинжээчийн:

1. Овог: \_\_\_\_\_ 2. Нэр: \_\_\_\_\_

3. Харьялагдах байгууллага: \_\_\_\_\_

4. Албан тушаал: \_\_\_\_\_

5. Мэргэжил: \_\_\_\_\_

6. Нийт ажилласан жил: \_\_\_\_\_

a. Үүнээс стандартчилал, тохирлын үнэлгээний салбарт ажилласан жил

b. Шинжээчийн буюу тохирлын үнэлгээний ажлын дадлага туршлага \_\_\_\_\_ жил  
\_\_\_\_\_ сар

7. Баталгаажуулалт, тохирлын үнэлгээний талаар мэргэшсэн байдал: \_\_\_\_\_


Шалгалтын нэр	Авбал зохих оноо	Шалгалтын оноо				Үнэлгээ өгсөн хүний гарын үсэг
		Хариулсан	Үүнээс зөв	Буруу	Үнэлгээ %	
Баталгаажуулалтын шинжээчийн онолын мэдлэгийн тестийн шалгалт	60					

Аттестатчиллын ажлын хэсгийн тусгай тэмдэглэл: \_\_\_\_\_

Ажлын хэсгийн дарга: .....

Гишүүд: .....

Стандарт, хэмжил зүйн газрын даргын  
2019 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн  
A/99 дугаар тушаалын 4-р хавсралт



### ЯРИЛЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Сургалтын нэр: Баталгаажуулалтын шинжээч  
Ярилцлагад орох хүний овог нэр: \_\_\_\_\_  
Тестийн шалгалтад авсан оноо: \_\_\_\_\_

Үзүүлэлт	Үнэлгээ			Тайлбар
	A\+5\	B\0\	C\10\	
Мэргэшлийн бэлтгэл				
Ажлын туршлага				
Шинжээчийн албан тушаалыг эрхлэх ур чадвар эзэмшсэн байдал				
Дүгнэлт				

Үнэлгээний тайлбар: А-маш сайн, В-хангалттай, С-хангалтгүй

Ажлын хэсгийн дарга: .....

Гишүүд:  
.....